

## ОРОН НУТГИЙН САНХҮҮГИЙН БИЕ ДААСАН БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛИЙН ШИНЖИЛГЭЭ

Н.Батжаргал\* , Ч.Анхбаяр\*\*, Б.Болормаа\*\*\*

**Хураангуй:** Энэхүү судалгааны ажлаар орон нутгийн бие даасан байдалд нөлөөлөх газарзүйн, хүн ам, улс төр, эдийн засгийн онцлогийг шинжилсэн. Бид 21 аймгийн 2012-2021 оны тоон мэдээллийг ашигласан ба Панел регрессээр үнэлгээ хийсэн. Үнэлгээний үр дүнд орон нутгийн бие даасан байдалд улс төр, эдийн засгийн онцлог хамгийн их нөлөөтэй байна. Дараа нь хүн амын онцлогоос илүүтэйгээр газарзүйн онцлог давамгайл байна.

**Түлхүүр үгс:** Бие даасан байдал, панел регресс, газарзүйн онцлог

### ANALYSIS OF FACTORS AFFECTING LOCAL FINANCIAL AUTONOMY

**Abstract:** This study analyzes the geographical, population, political, and economic characteristics that affect local autonomy. We used data from 21 provinces from 2012 to 2021 and evaluated it by panel regression. As a result of the evaluation, political and economic characteristics have the most significant impact on local autonomy. Afterward, there are geographical features dominated rather than population.

**Keywords:** Autonomy, panel regression, geographical features

---

\* МУИС, Бизнесийн сургууль (E-mail): batjargal\_nadmid@num.edu.mn

\*\* МУИС, Бизнесийн сургууль (E-mail): ankhbayar.ch@num.edu.mn

\*\*\* МУИС, Бизнесийн сургууль (E-mail): bolormaa.b@num.edu.mn

## Удиртгал

Бүс нутгийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө, нөөц боломжийг тооцох нь зайлшгүй учраас “Орон нутгийн санхүүгийн асуудал” 1960-аад оны үеэс эхлэн хөгжиж буй улс орны анхаарлыг татах болсон. Түүнчлэн АНУ-ын их хямрал, Норвеги зэрэг Европын улс орнууд, Япон, Австрали зэрэг улс орнуудын муж орон нутагт тохиолдож байсан санхүүгийн хүндрэлийн дараагаас орон нутгийн санхүүгийн байдлыг үнэлэх, тодорхойлох судалгаанууд хийгдэх болжээ (Vegskner & Tuladhar, 2009).

Санхүүгийн төвлөрлийг сааруулах онолын хүрээнд Бучанан, Масгрейв, Оейтс, Самуэльсон нар төсвийн эрх мэдлийг орон нутагт шилжүүлэх, ард иргэдээ нийгмийн бараагаар хангах үүргийг орон нутгийн түвшинд гүйцэтгэх талаар дурдаж байв. Гэхдээ энэ нь тийм ч амархан биш бөгөөд урт удаан хугацаанд шийдвэрлэх асуудал юм (Psycharis, Zoi, & Piopoulou, 2015). “Орон нутгийн санхүүгийн бие даасан байдлын тохиромжтой тоон үзүүлэлтийг тодорхойлох”-д төсвийн төвлөрлийг сааруулах үйл явц болон макро эдийн засгийн үзүүлэлт, эдийн засгийн өсөлт, төсвийн хэмжээ зэрэг хувьсагчдын харилцан хамаарлыг тогтоох зорилготой судалгааны ажлууд 1980-аад оны дунд үеэс эхлэн эрчимтэй хийгдэж эхэлсэн байна (Beer-Tyth, 2009).

Санхүүгийн бие даасан байдал нь орон нутгийн засаг захиргааны нэгж төвлөрсөн төсвөөс хамааралгүйгээр татвар ногдуулах, орлого цуглуулах, санхүүгийн эх үүсвэрийг хуваарилах эрх чөлөөг илэрхийлдэг бөгөөд тус эрх чөлөөг өрсөлдөх чадвар улам бүр нэмэгдүүлдэг. Түүнчлэн орон нутгийн засаг захиргаа улсын болон гадны эх үүсвэрийн санхүүжилтээс хамаарахгүй, бусдын хяналт нөлөөлөлд автахгүй байх нөхцөл байдлыг хэлэх (CICA, 1997) ба орон нутаг санхүүгийн эрх мэдэлтэй байх нь өөрийн орлогыг нэмэгдүүлж, санхүүгийн бие даасан байдлыг дээшлүүлнэ.

2000 он хүртэлх дээрх чиглэлээр хийгдсэн судалгааны ажлын дийлэнх нь ОУВС (Олон улсын валютын сан)-ийн Засгийн газрын санхүүгийн статистикт суурилж байсан ба орон нутгийн санхүүгийн бие даасан байдлыг үнэлэхэд тухайн орон нутгийн өөрийн орлого (зарлага)-ыг төсвийн нийт орлого (зарлага) эсвэл ДНБ-д харьцуулж тооцож байна. Тус аргачлалын хувьд дараах сул талууд байгаа ч одоо хүртэл ашигласаар байна.

- *Зарлагын тал дээр* орон нутгийн засаг захиргааны үндсэн болон нэмэлт зардлыг ялгаж чаддаггүй. Төвлөрлийг сааруулсан засгийн газрын нэгжийн хувьд үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх эрх хязгаарлагдмал эсвэл эрхгүй байсан ч үндсэн чиг үүрэгт хамаарах зардал нь орон нутгийн зардалд тооцогддог. Түүнээс гадна орон нутгаас улсын төсөвт

шилжүүлж байгаа мөнгөн шилжүүлэг хүртэл зарлагад хамаарагдана.

- *Орлогын тал дээр* орон нутгийн бие даасан байдал, онцлогоос хамаарч орлогын эх үүсвэр ялгаатай байж болох ч орон нутгийн орлогын төрөл бүрийн эх үүсвэрүүдийг ялгадаггүй. Үүнээс гадна ОУВС-ийн статистикт төсөв хоорондын шилжүүлгийн хэдэн хувь нь ерөнхий болон тусгай зориулалтаар хийгддэг, тэдгээрийн хуваарилалт нь объектив шалгуур эсвэл субъектив байдлаар хийгддэг эсэхийг харуулдаггүй.

Орон нутгийн санхүүгийн бие даасан байдлын үнэлгээний талаарх судалгаа шинжилгээнүүд 2000 оноос эхлэн орон нутгийн засаг захиргааны төвлөрлийг сааруулах явцад тулгардаг янз бүрийн гадаад хязгаарлалтыг тодорхойлох, ялгааг олж тогтоох, нөлөөлөх хүчин зүйлүүдийг тодорхойлоход чиглэж эхэлсэн.

Монгол улсын хувьд төвлөрсөн төсөв, орон нутгийн төсвийн харилцааг боловсронгуй болгох, төсвийн зарлагын үр ашгийг дээшлүүлэх, урсгал тэнцлийг хангах нэрийн дор явуулж буй бодлого, үйл ажиллагаа нь *орон нутгийн санхүүгийн бие даасан байдлыг дээшлүүлэх* гэж байгаа мэт боловч, одоо хэр нь алдагдалтай төсвийг дээрээс санхүүжүүлж өгнө гэсэн хандлагаар төсвийн хүрээнд орон нутгийн хүлээх үүрэг, бүтээлч үйл ажиллагаа улам бүр муудаж, орлогоо нэмэгдүүлж, зардлаа танах сонирхлыг нь бууруулж байна. Иймд орон нутгийн санхүүгийн бие даасан байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг онол арга зүйн хувьд оновчтой тодорхойлох нь төсвийн алдагдлыг санхүүгийн дэмжлэгээр шууд шийдвэрлэдэг асуудлыг хязгаарлах, төсвийн хуваарилалтын оновчтой системийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Судалгааны ажил нь дараах бүтэцтэй байна. Хоёрдугаар хэсэгт орон нутгийн санхүүгийн бие даасан байдлыг хэмжих арга үзүүлэлт, хэмжигдэхүүний талаар авч үзнэ. Гуравдугаар хэсэгт эмпирик загварыг тайлбарлана. Дөрөвдүгээр хэсэгт загвартай холбоотой тоон өгөгдөл, тэдгээрийн тайлбарыг хийнэ. Тавдугаар хэсэгт шинжилгээний үр дүнг харуулах бол сүүлийн хэсэгт тайлбар хийн, дүгнэлт гаргана.

### **Орон нутгийн санхүүгийн бие даасан байдлын хэмжигдэхүүн**

Уламжлалт үзлээр бие даасан байдал гэдэг ойлголтын мөн чанар нь ямар нэгэн гадаадын тусламж, дэмжлэгээс хамаарахгүйгээр бие даасан бодлого явуулах чадвартай байхыг хэлдэг. Эдийн засгийн бие даасан аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтэд дараах үзүүлэлтүүд орно (Сувд, 2002). Үүнд:

- Тогтвортой эдийн засгийн өсөлт
- Инфляц

- Ажил эрхлэлт
- Ажилгүйдлийн түвшин
- Ядуурал, эмзэг байдлын түвшин
- ДНБ-д өрийн эзлэх хувь
- Өрсөлдөх чадварын үзүүлэлтүүд
- Санхүүгийн аюулгүй байдлын үзүүлэлтүүд орно.

Эдгээр үзүүлэлтүүдийг орон нутгийн санхүүгийн бие даасан байдалд нөлөөлөх хүчин зүйлээр тооцож болох юм. Орон нутгийн санхүүгийн бие даасан байдал нь орон нутгийн татварын суурь, бүс нутагт хуваарилагдаж байгаа татварын орлого, орон нутгийн өмч, татварын боловсронгуй тогтолцооноос шууд хамаарна (Yilmaz, Vaillancourt, & Dafflon, 2012).

Орон нутгийн санхүүгийн бие даасан байдлыг үнэлэх талаар хийгдсэн судалгаанууд хязгаарлагдмал байгаа ч шалгуур үзүүлэлтийг тодорхойлох, үнэлгээний арга, загварыг боловсруулах оролдлогууд хэд хэдэн удаа гарсан байна (Padovani & Scorsone, 2011). Гэвч өгөгдлийн хүртээмжээс шалтгаалан, хэдэн хувьсах хэмжигдэхүүнээр хязгаарлагддаг (Kloha, Weissert, & Kleine, 2005).

Зафра Гомез, Лопез-Хернандез болон Хернандез-Бастида нар орон нутгийн санхүүгийн нөхцөл байдлыг богино хугацааны болон төсвийн төлбөрийн чадвараар үнэлэх загваруудыг тодорхойлсон ба төсвийн төлбөрийн чадварыг санхүүгийн бие даасан байдлын 3 үзүүлэлтээр хэмжихийг санал болгосон (Gomez, Hernandez, & Bastida, 2009). Үүнд:

- 1) Тайлант жилийн санхүүгийн бие даасан байдлын индекс: Тайлант жилийн төсвийн өр төлбөрийг тайлант жилийн төсвийн тусламжаас бусад авлагад харьцуулж тооцно.
- 2) Санхүүгийн бие даасан байдлын индекс: Төсвийн өр төлбөрийг төсвийн тусламжаас бусад авлагад харьцуулна.
- 3) Төсвийн орлогын индекс: Төсвийн авлагыг тухайн 1 жилийн төсвийн цэвэр авлагад харьцуулна. Эдгээр үзүүлэлтүүдийг хүснэгт 1-т нэгтгэн харуулав.

*Хүснэгт 1. Орон нутгийн санхүүгийн бие даасан байдлыг үнэлэх үзүүлэлт*

Хэмжигдэхүүн	Үзүүлэлт
<b>Төсвийн бие даасан байдал</b>	Тайлант жилийн санхүүгийн бие даасан байдлын индекс=Тайлант жилийн төсвийн өр төлбөр/Тайлант жилийн тусламжаас бусад төсвийн авлага Санхүүгийн бие даасан байдлын индекс=Төсвийн өр төлбөр/Тусламжаас бусад төсвийн авлага Төсвийн орлогын индекс=Төсвийн авлага/Тухайн жилийн төсвийн цэвэр авлага

Эх сурвалж: (Gomez, Hernandez, & Bastida, 2009)

Канадын мэргэшсэн нягтлан бодогчдын институтээс орон нутгийн санхүүгийн эрүүл байдлыг тодорхойлох зорилгоор гаргасан шалгуур үзүүлэлтэд орон нутгийн өөрийн орлогыг нийт орлого эсвэл нийт зарлагад харьцуулах замаар тооцсон (CICA, 1997). Үүнийг хүснэгт 2-т харуулав.

*Хүснэгт 2. Санхүүгийн бие даасан байдлын харьцааны үзүүлэлт*

Хэмжигдэхүүн	Үзүүлэлт
Санхүүгийн бие даасан байдлын харьцаа	Харьцаа А= Нийт өөрийн орлого/ Нийт орлого Харьцаа В= Нийт өөрийн орлого/ Нийт зарлага

Эх сурвалж: (CICA, 1997)

Дээрх 2 харьцаа нь өндөр байхын хэрээр орон нутаг санхүүгээ бие даан удирдах чадвартай байгааг харуулна.

Индонезийн төв Жавагийн 35 муж, хотуудын санхүүгийн нөхцөл байдлыг судалсан Пративигийн судалгааны ажилд орон нутгийн санхүүгийн бие даасан байдлыг тодорхойлохдоо орон нутгийн өөрийн орлогыг улсын төсвөөс авсан зээл, тусламжийн дүнд харьцуулах замаар тооцсон (Pratiwi, 2017). Энэхүү харьцаа нь нэг талаас орон нутгийн болон улсын төсөв хоорондын хамаарлыг харах, нөгөө талаас орон нутгийг орлогын хандлагаар бүсчлэн ангилах бололцоог олгож байна. Тус судалгааны ажилд санхүүгийн бие даасан байдлыг дараах байдлаар ангилсан.

*Хүснэгт 3. Орон нутгийн санхүүгийн чадварын түвшний хамаарал*

Бие даасан байдлын харьцаа	Орон нутгийн санхүүгийн чадвар	Бие даасан байдлын түвшин	Хамаарлын төлөв
<=25	Маш муу	Хангалтгүй, чадваргүй	Захирагдсан, зааврын дагуу (instructive)
26-50	Муу	Хангалттай бие даагаагүй	Зөвлөх (consultative)
51-75	Дунд	Бие дааж байгаа	Оролцооны (participative)
76-100	Өндөр	Бүрэн бие даасан	Төлөөллийн (delegative)

Эх сурвалж: (Pratiwi, 2017)

Хүснэгтээс харахад улсын төсвөөс авсан тусламжийн орлогыг орон нутаг өөрийнхөө орлогоор хангах харьцаа 51-75 хувь байвал орон нутаг санхүүгийн хувьд бие дааж байгаа, 76-100 байх нь орон нутаг бүрэн бие даасан байгааг харуулна.

Унгар улсын санхүүгийн төвлөрлийг сааруулах үйл явцын нөлөө болон орон нутгийн санхүүгийн бие даасан байдлын талаар судалсан диссертацийн ажилд доктор Кристиана “Орон нутгийн санхүүгийн бие даасан байдал”-ыг үндсэн 3 үзүүлэлтээр тодорхойлж болно (Beer-Tyth, 2009) гэж үзсэн. Үүнд:

- 1) *Орон нутгийн зарлагын бие даасан байдал* - орон нутгийн зарлагын нийт хэмжээ, зүйл ангиллыг бүхэлд нь тодорхойлох, ард иргэдийнхээ эрэлт хэрэгцээнд нийцүүлэн нийгмийн бараа, үйлчилгээг хуваарилах эрхийг илэрхийлнэ.
- 2) *Орон нутгийн орлогын бие даасан байдал* - санхүүгийн нөөц эх үүсвэрийг бүрдүүлэх, төсөвт орлого төвлөрүүлэх төрөл бүрийн эх үүсвэрийн хувь хэмжээг тодорхойлох эрхийг илэрхийлнэ.
- 3) *Орон нутгийн сангийн бие даасан байдал* - төрийн оролцооны янз бүрийн түвшинд орлогыг зарлагын түвшинд тохируулах эрх, чадамжийг илэрхийлнэ.

Эдгээр үзүүлэлтүүдийн хэмжигдэхүүнийг дараах байдлаар тооцно.

➤ Орон нутгийн зарлагын бие даасан байдлын хэмжигдэхүүн:

$$SEA_A = \frac{OE_{SNG}}{O_{GG}} \quad (1)$$

$$SEA_B = \frac{OE_{SNG}}{GDP} \quad (2)$$

- Орон нутгийн орлогын бие даасан байдлын байдлын хэмжигдэхүүн:

$$SRA = \frac{OR_{SNG}}{TR_{SNG}}$$

$$OR_{SNG} = T_{discr} + NT_{discr} + GG_{obj} + SG_{uncond} \quad (3)$$

$$TR_{SNG} = T + NT + GG + SG$$

- Орон нутгийн сангийн бие даасан байдлын хэмжигдэхүүн:

$$CI_{SRA} = \frac{AT_{SCG}}{T_{SCG} + T_{CG}} \quad (4)$$

Энд  $SEA_A$ ,  $SEA_B$  -Орон нутгийн зарлагын бие даасан байдал

$OE_{SNG}$  -Орон нутгийн зардал

$O_{CG}$  -Засгийн газрын хөрөнгө оруулалт, зарлага

$GDP$  -Дотоодын нийт бүтээгдэхүүн

$SRA$  -Орон нутгийн орлогын бие даасан байдал

$OR_{SNG}$  -Орон нутгийн өөрийн орлого

$TR_{SNG}$  -Орон нутгийн нийт орлого

$T_{discr}$  -Орон нутгийн татварын орлого

$NT_{discr}$  -Орон нутгийн татварын бус орлого

$GG_{obj}$  -Ерөнхий зориулалтын тусламж, шилжүүлэг

$SG_{uncond}$  -Тусгай зориулалтын тусламж, шилжүүлэг

$CI_{SRA}$  -Орон нутгийн сангийн бие даасан байдал

$AT_{SCG}$  -Орон нутгийн татварын орлого

$T_{SCG}$  -Орон нутгаас тогтоодог татварын орлого

$T_{CG}$  -Төвлөрсөн төсвөөс тогтоодог татварын орлого

Дээрх томъёолол нь орон нутаг санхүүгийн хувьд биеэ даах асуудал нь орлого, зарлага, сангийн хувьд биеэ даахтай холбоотой бөгөөд үндсэндээ орон нутгийн татварын орлогоос хамаардаг болохыг харуулж байна.

Ривенбарк (2009), Роеник, Алисон (2010) нар үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг орон нутаг өөрөө хариуцах чадвараар тухайн орон

нутгийн санхүүгийн бие даасан байдлыг тодорхойлно гэж үзсэн. Ритонга (2014) Индонезийн орон нутгийн санхүүгийн нөхцөл байдлыг орон нутгийн өөрийн орлогыг нийт орлого эсвэл нийт зарлагад харьцуулах замаар тооцсон. Түүнчлэн орон нутгийн өөрийн орлого нэмэгдэхийн хэрээр санхүүгийн бие даасан байдал нэмэгддэг. Харин орон нутагт стратегийн бус орлого бүрдүүлэх боломжийг олгох нь санхүүгийн бие даасан байдлыг бууруулдаг байна.

Орон нутгийн санхүү нь төвлөрсөн төсвийн орлогоос ихээхэн хамааралтай, хязгаарлагдмал татварын орлогын эх үүсвэр бүхий Грек улсын “Орон нутгийн санхүүгийн бие даасан байдал”-ыг судалсан судалгааны ажилд төсвийн орлого, зарлага, татварын орлогын бие даасан байдлын үзүүлэлтийг ашиглахаас гадна эдийн засаг, хүн ам, улс төр, газар зүйн хүчин зүйлийн нөлөөллийг авч үзсэн (Psycharis, Zoi, & Iliopoulou, 2015). Тус судалгааны ажилд орон нутгийн санхүүгийн бие даасан байдлыг дараах үзүүлэлтээр тооцсон.

### **Орлогын бие даасан байдал**

Орон нутгийн өөрийн орлогыг нийт орлогод харьцуулсан харьцаагаар тодорхойлно. Тус харьцаа өндөр буюу орон нутгийн нийт орлогод өөрийн орлогын эзлэх хувь хэмжээ өндөр байх тусам бие даасан байдал нэмэгдэнэ.

### **Дотоод орлогын бие даасан байдал**

Орон нутгийн өөрийн орлогыг нийт орлого болон өөрийн орлогын зөрүүнд харьцуулж тооцно. Тус харьцааны тусламжтай орон нутгийн дотоод орлогын бусдаас хамаарах байдлыг тодорхойлох ба харьцаа өндөр байхын хэрээр бие даасан байдал өндөр болно.

### **Татварын орлогын бие даасан байдал**

Төвлөрсөн төсвөөс орон нутгийн орлогын хамаарах байдлыг тодорхойлох үүднээс татварын орлогыг нийт орлогод (санхүүгийн дэмжлэг, тусламжийн орлогыг тооцсон) харьцуулсан харьцааг ашигладаг.

Санхүү, төсвийн төвлөрлийг сааруулах үйл явцын стандарт хэмжигдэхүүн нь “Орон нутгийн татварын бие даасан байдал” боловч Грек зэрэг зарим улсын хувьд манай улстай ижил орон нутгийн засаг захиргаа нь өөрийн нутаг дэвсгэрт татвар ногдуулах, хуульчлан тогтоох эрхгүй, хэдий тийм боловч тодорхой татварыг урьдчилан тогтоосон хязгаарын хүрээнд тохируулж болдог байна.

### **Зарлагын бие даасан байдал**

Төвлөрсөн төсвийн тусламж буюу шилжүүлгийн орлогыг нийт зардалд харьцуулсан харьцаа нь орон нутаг төвлөрсөн төсвийн тусламжийн орлогоос хэр хамааралтайг харуулна. Орлогын бие даасан байдал их байхад зарлагын бие даасан байдал бага байдаг. Энэ нь төвлөрсөн төсвийн тусламжаас илүү өөрийн орлогод найддаг болохыг харуулна.

### **Эмпирик загвар**

Монгол улсын 21 аймгийн орон нутгийн санхүүгийн бие даасан байдлыг тодорхойлох үүднээс газар зүй, хүн ам, улс төр, эдийн засгийн зэрэг бие даасан байдлыг тодорхойлоход нөлөөлөх хүчин зүйлийг авч үзсэн. Эмпирик шинжилгээний хүрээнд бид дараах Панел регрессийн загварыг дэвшүүлж байна.

$$Y_{it} = \beta' X_{it} + v_{it} \quad (1)$$

Энд  $Y_{it}$  —нь  $t$  хугацаан дахь  $i$  орон нутгийн төвлөрлийг сааруулсан, бие даасан байдлын хэмжүүрийг илэрхийлнэ. Үүнд орлого, дотоод орлого, татварын орлого болон зарлагын бие даасан байдал хамаарагдана.  $X_{it}$  — нь тайлбарлагч хувьсагчийн векторыг илэрхийлэх ба газарзүй, хүн ам, улс төр болон эдийн засгийн онцлогуудаар нь авч үзнэ.  $v_{it}$  —нь нийт алдааг илэрхийлэх ба  $v_{it} = \mu_{it} + \omega_{it}$  байна. Хэрэв хугацаанаас үл хамааран  $\mu_i$  тодорхойлогдож байвал үүнийг тогтмол нөлөөтэй Панел регрессийн загвар гэнэ. Эсрэг тохиолдолд санамсаргүй нөлөөтэй гэж үзэх ба аль нь тохиромжтой эсэхийг Хаусман тестээр тодорхойлно.

### **Тайлбарлагч хувьсагчид**

#### *Газарзүйн онцлог*

Монгол орон дөрвөн улирал, эх газрын эрс тэс уур амьсгалтай. Нутаг дэвсгэрийн газрын гадарга янз бүрийн хэлбэр дүрстэй, өндөр уулс, нам уулс, ухаа гүвээ, цав толгод өргөн уудам тал, хөндий, хотгор хосолсон ой тайга, хээр, говь, цөл бүхий далайн төвшнөөс дээш дунджаар 1580 метр өргөгдсөн. Нутаг дэвсгэрийн 80 гаруй хувь нь далайн төвшнөөс 1000 гаруй метр өндөрт орших бөгөөд баруун хэсэгтээ далайн төвшнөөс дээш дунджаар 2500-3500 метр өргөгдсөн оргил бүхий Монгол Алтай, Говь Алтайн нуруу, нутгийн баруун

болон хойд талаар 2000-2500 метр өндөр Хангай, Хэнтий нуруу, Хөвсгөлийн уулс оршино. Харин зүүн ба өмнөд хэсгээр 1000-1500 метр өндөртэй Дорнод Монголын тал, нам уулс, цав толгод бүхий говь нутгаас бүрддэг (Бадамсайхан, 2012).

Ойн сав газар, гадаргын усны нөөц ихтэй байх нь самар, жимс, мөөг, навч ургамал түүх, загас жараахай барихаас эхлээд газар тариалан эрхлэх, түүхий эд нөөц материалыг ашиглан бичил, жижиг үйлдвэрлэл эрхлэх замаар хувь хүн, өрх гэрийн амьжиргаанд ач холбогдолтой. Ойн сав газар болон гадаргын усны нөөц<sup>2</sup> их байх нь орон нутгийн санхүүгийн бие даасан байдлыг дээшлүүлнэ. Газарзүйн онцлог хэсэгт тухайн аймаг далайн төвшнөөс дээш хэдэн метрийн өндөрт оршиж байгаа, тухайн аймгийн ойн сав газрын хэмжээ, гадаргын усны нөөц, хүн амын нягтрал зэрэг үзүүлэлтүүдийг авч үзнэ.

### *Хүн амын онцлог*

Улс орон нутгийн хөгжилд хүн амын боловсрол, ажил эрхлэлтийн түвшинтэй холбоотой, хувь хүний чадвар, боловсрол, боломж орон нутгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг (Psycharis, Zoi, & Ilioroulou, 2015). Энэ хэсэгт тухайн орон нутгийн хүн амын тоо<sup>3</sup>, шилжих хөдөлгөөн<sup>4</sup>, боловсролын түвшин<sup>5</sup>, эдийн засгийн идэвхгүй хүн амын<sup>6</sup> тухайн орон нутгийн хүн амд эзлэх хувийн жин зэрэг үзүүлэлтүүдийг хамааруулна. Шилжих хөдөлгөөнийг тухайн орон нутагт ирсэн хүнээс явсан хүнийг хасаж тооцсон болно.

<sup>2</sup> БОАЖЯ-наас авсан мэдээллээр гадаргын усанд гол мөрөн, нуур тойром, булаг шанд, усан сан буюу хөв цөөрмийг оруулж тооцдог.

<sup>3</sup> ҮСХ-ноос авсан мэдээллээр тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа хүн ам-Монгол Улсын засаг захиргааны нэгжид 183 хоног буюу 6 сараас дээш хугацаагаар оршин сууж байгаа хүн амыг ойлгоно.

<sup>4</sup> ҮСХ-ноос авсан мэдээллээр тухайн засаг захиргааны нэгж хоорондох, байршлын хувьд (хот, хөдөө) явагдах хүн амын суурьшлын өөрчлөлтөөр тодорхойлдог. Шилжих хөдөлгөөний үндсэн үзүүлэлт нь шилжин ирэгчдийн тоо, шилжин явагчдын тоо болно.

<sup>5</sup> ҮСХ-ноос авсан мэдээллээр боловсролын түвшинг насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлагдалт болон бүх шатны боловсролд хамрагдалтын түвшингээр тооцдог.

<sup>6</sup> ҮСХ-ноос авсан мэдээллээр эдийн засгийн идэвхгүй буюу ажиллах хүчнээс гадуурх хүн амд хөдөлмөрийн нас хүрээгүй, суралцдаг, тэтгэвэрт гарсан, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй, жирэмсэн (хүүхэд асарсан), бусдыг асарсан, тухайн жилд цэргээс халагдсан, тухайн жилд сургууль төгссөн, шилжин суурьшсан, аав ээж, гэр бүл үр хүүхдээ дагаад явсан, хүүхдээ сургуульд сургахаар ажиллахаа больсон, гадаадад амьдарч байгаад ирсэн, засан хүмүүжүүлэх газраас суллагдсан, байгууллага татан буугдсан, цомхотголд орсон, улирлын чанартай ажил хийдэг, мэргэжил, дадлага туршлага байхгүй, мэргэжилд тохирох ажил олдохгүй, ажил хайгаад олдохгүй байгаа, байгалийн гамшиг, аюулт үзэгдэл өртөж малгүй болсон (ган, зудны үе), ажиллах сонирхолгүй байсан, цалин бага учраас ажиллах сонирхолгүй, үүсээд байгаа цар тахлын улмаас ажилгүй болсон, малчин, бусад гэсэн хүмүүсийг оруулж тооцдог байна.

### *Улс төр, эдийн засгийн онцлог*

Төвлөрсөн төсвөөс хэт хамааралтай Монгол улсын хувьд орон нутгийн орлогын бие даасан байдлыг хангахад төсвийн орлогын түвшинд улс төрийн оролцоо их байдаг. Иймд улс төрийн оролцоог харуулахын тулд *Сонгуулийг тооцсон* бөгөөд тухайн орон нутагт сонгуулийн үр дүнгээр (2012, 2016, 2020 оны УИХ-ын сонгуулийн тухайн аймгийн үр дүн) эрх баригч намын төлөөлөл сонгогдсон бол 1, үгүй бол 0 гэв. Харин *Улс төрийн эрх мэдлийн* хувьд тухайн орон нутагт сонгогдсон УИХ-ын гишүүн дараагийн сонгуульд (2008, 2012, 2016, 2020 оны УИХ-ын сонгуулийн үр дүн) тухайн аймагт дахин сонгогдсон нөхцөлд 1, анх удаа бол 0 гэсэн оноо өгөв. Өрсөлдөх чадварын үзүүлэлтийн хувьд тухайн аймгийн өрсөлдөх чадварын индекс нэмэгдэхийн хэрээр орон нутгийн санхүүгийн бие даасан байдал нэмэгдэнэ. Энэ хэсэгт улс төрийн эрх мэдэл, сонгууль, өрсөлдөх чадварын индекс, ажилгүйдлийн түвшин<sup>7</sup>, инфляц зэрэг үзүүлэлтүүдийг хамааруулав.

### **Тоон өгөгдөл, тэдгээрийн тайлбар**

Судалгаанд газарзүйн онцлогтой холбоотой аймгуудын ойн сангийн талбайн хэмжээ, далайн төвшнөөс дээш өндрийн мэдээллийг ШУА (Шинжлэх ухааны академи)-ийн Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгээс, хүн амын нягтралын мэдээллийг ҮСХ (Үндэсний статистикийн хороо)-ны статистикийн мэдээллийн нэгдсэн сангаас, гадаргын усны мэдээллийг БОАЖЯ (Байгаль орчин, аялал жуулчлалын яам)-ны ус рашааны мэдээллийн сангаас тус тус авсан.

Улс төр, эдийн засгийн онцлогтой холбоотой сонгуулийн үр дүнгийн мэдээллийг СЕХ (Сонгуулийн ерөнхий хороо)-ны 2008, 2012, 2016, 2020 оны сонгуулийн үр дүнгийн мэдээллээс, өрсөлдөх чадварын индексийн мэдээллийг 2012-2021 оны “Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан”-гаас, эдийн засгийн идэвхгүй хүн амын тоон мэдээллийг ҮСХ (Үндэсний статистикийн хороо)-ны статистикийн мэдээллийн нэгдсэн сангаас, ажилгүйдлийн түвшний мэдээллийг “Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан”-гаас тус тус авч ашиглав.

Хүн амын онцлогтой холбоотой хүн амын тоо, шилжих хөдөлгөөн, боловсролын түвшний индексийн мэдээллийг ҮСХ (Үндэсний статистикийн хороо)-ны статистикийн мэдээллийн нэгдсэн сангаас авсан.

### Орон нутгийн санхүүгийн бие даасан байдалтай холбоотой орон нутгийн

<sup>7</sup> ҮСХ-ноос авсан мэдээллээр ажилгүйдлийн түвшинг ажилгүй иргэдийн тоог эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд харьцуулж тооцдог. Ажилгүй иргэн гэж тухайн хугацаанд ажилгүй байсан, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэнийг ойлгоно. Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажллах хүч)-д Үндэсний тооцооны системийн хүрээнд, тухайн цаг хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч, нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй иргэдийг хамруулна.

төсвийн нийт орлого, нийт зарлагад холбогдох мэдээллийг ҮСХ (Үндэсний статистикийн хороо)-ны статистикийн мэдээллийн нэгдсэн сангаас тус тус авсан болно. Эдгээртэй холбогдох тоон өгөгдлийн мэдээллийг хүснэгт 4-т харуулав.

Хүснэгт 4. Тайлбарлагч хувьсагчид

Үзүүлэлтүүд	Хамгийн их	Хамгийн бага	Дундаж	Стандарт хазайлт	Нормаль тархалтын магадлал
Бие даасан байдлын хэмжүүр					
Орлогын бие даасан байдал (%)	1.000	0.092	0.323	0.231	0.000
Татварын орлогын бие даасан байдал (%)	0.969	0.081	0.272	0.206	0.000
Дотоод орлогын бие даасан байдал (%)	4.849	0.000	0.533	0.711	0.000
Зардлын бие даасан байдал (%)	0.991	0.000	0.688	0.231	0.000
Газарзүйн онцлог					
Далайн төвшнөөс дээш өндөр (м)	2181	626	1334	409	0.032
Гадаргын усны эх үүсвэрийн тоо	2758	41	1157	785	0.047
Ойн сангийн талбай (мян.га)	16737	0	1594	3525	0.000
Хүн амын нягтрал (/км <sup>2</sup> )	135.9	0.34	8.55	27	0.000
Хүн амын онцлог					
Хүн амын тоо	137628	14150	79667	25103	0.000
Шилжилт хөдөлгөөн	2424	-3183	-606	758	0.000
Боловсролын түвшний индекс (%)	0.845	0.541	0.621	0.059	0.000
Эдийн засгийн идэвхгүй хүн ам (%)	0.474	0.129	0.216	0.061	0.000
Улс төр, эдийн засгийн онцлог					
Улс төрийн эрх мэдэл	3	0	0.281	0.613	0.000
Сонгууль	1	0	0.213	0.382	0.000
Өрсөлдөх чадварын индекс	100	27.7	65.82	17.64	0.089
Ажилгүйдлийн түвшин (%)	31	0.30	9.08	5.01	0.000
Инфляц (%)	23.7	-3.8	7.7	4.97	0.016

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Хүснэгт 4-т үндэслэн дараах тайлбарыг хийж болно. Үүнд:

- Орлогын болон татварын орлогын бие даасан байдлын түүврийн дундаж нь хүснэгт 3-т үндэслэн тодорхойлоход хангалттай биеэ даагаагүй байна.
- Далайн төвшнөөс дээш өндөр, гадаргын усны эх үүсвэрийн тооны стандарт хазайлт нь түүврийн дунджийн хүрээнд байна. Харин ойн сангийн талбай болон хүн амын нягтрал нь түүврийн дунджаасаа өндөр хазайжээ.
- Хүн амын тоо ихдээ 137628, багадаа 14150 байна. Шилжилт хөдөлгөөний хувьд шилжин явагсад давамгайл байна. Боловсролын түвшин дунджаар 0.621 бол эдийн засгийн идэвхгүй хүн ам дунджаар 21.6 хувь байна.
- Улс төрийн эрх мэдэл болон сонгуулийн дүр зураглалын хувьд дунджаас хазайх хазайлт ихтэй байна. Өрсөлдөх чадварын хувьд дундаж үзүүлэлт 65.82 байна. Нийт түүврийн хувьд дунджаар ажилгүйдлийн түвшин 9.1 хувь, инфляц
- 7.7 хувь байна.
- Авч үзэж буй бүх үзүүлэлтүүд нормаль тархалтын шинжийг хангахгүй байна.

Хүснэгт 5-д хамааран хувьсагч болон тайлбарлагч хувьсагчуудын харилцан хамаарлын корреляцийн матрицыг харуулав.

Хүснэгт 5. Корреляцийн матриц

	Орлогын бие даасан байдал	Татварын орлогын бие даасан байдал	Дотоод орлогын бие даасан байдал	Зарлагын бие даасан байдал
Газарзүйн онцлог				
Далайн төвшнөөс дээш өндөр	-0.2286 [0.0008]	-0.2425 [0.0004]	-0.0422 [0.5434]	0.2396 [0.0005]
Усны эх үүсвэрийн тоо	-0.4019 [0.0000]	-0.3889 [0.0000]	-0.3239 [0.0000]	0.3963 [0.0000]
Ойн сангийн талбай	-0.0598 [0.3882]	-0.0535 [0.4405]	-0.1053 [0.1281]	0.05967 [0.3896]
Хүн амын нягтрал	0.3125 [0.0000]	0.3638 [0.0000]	0.2520 [0.0002]	-0.3043 [0.0000]
Хүн амын онцлог				
Хүн амын тоо	-0.1586 [0.0215]	-0.1344 [0.0517]	-0.1346 [0.0514]	0.1504 [0.0293]

Шилжилт хөдөлгөөн	0.2962 [0.0000]	0.2739 [0.0001]	0.1988 [0.0038]	-0.3192 [0.0000]
Боловсролын индекс	0.3264 [0.0000]	0.3684 [0.0000]	0.2209 [0.0013]	-0.3177 [0.0000]
Эдийн засгийн идэвхгүй хүн ам	0.1207 [0.0810]	0.1439 [0.0371]	0.0343 [0.6211]	-0.1175 [0.0894]
Улс төр, эдийн засгийн онцлог				
Улс төрийн эрх мэдэл	0.1721 [0.0125]	0.1811 [0.0085]	0.0143 [0.8359]	-0.1677 [0.0150]
Сонгууль	0.2039 [0.0030]	0.2129 [0.0019]	0.0033 [0.9618]	-0.1990 [0.0038]
Өрсөлдөх чадварын индекс	0.4196 [0.0000]	0.4082 [0.0000]	0.3801 [0.0000]	-0.4214 [0.000]
Ажилгүйдлийн түвшин	0.0688 [0.3213]	0.1042 [0.1325]	0.0273 [0.6938]	-0.0768 [0.267]
Инфляц	0.2705 [0.001]	0.2578 [0.0002]	0.1262 [0.0679]	-0.2357 [0.0006]

Энд [\*] дотор тухайн корреляцийн коэффициентийн t статистикийн магадлалыг харуулав.

Корреляцийн матрицаас харахад бие даасан байдлын хэмжүүрт өрсөлдөх чадварын индекс, усны эх үүсвэрийн тоо, шилжилт хөдөлгөөн хамгийн нөлөөтэй. Статистикийн 1 хувийн магадлалын түвшинд бие даасан байдлын хэмжүүрт нөлөөгүй үзүүлэлтүүдэд ойн сангийн талбай, хүн амын тоо, эдийн засгийн идэвхгүй хүн ам, ажилгүйдлийн түвшин хамаарагдахаар байна.

Орлогын бие даасан байдлын үзүүлэлтүүдэд (орлого, татварын орлого, дотоод орлого) корреляцийн утгыг харахад ерөнхийдөө газарзүйн онцлог сөрөг, хүн амын онцлог эерэг, улс төр, эдийн засгийн онцлог эерэг нөлөөтэй. Гэсэн хэдий ч корреляцийн хүч харилцан адилгүй ба мэдэгдэхүйц түвшнээс бага байна.

### Эмпирик шинжилгээний үр дүн

Панел регрессийн үр дүнг хүснэгт 6-д харуулав. Үнэлгээнээс харахад Хаусманы тестээр тогтмол нөлөөллийн загвар тодорхойлогдож байна. Тус загварын үнэлэгдсэн параметрууд панел регрессийн тэгшитгэлийн хувьд харилцан адилгүй байгаа ба орлогын, татварын орлогын, дотоод орлогын болон зарлагын бие даасан байдлын тэгшитгэлүүд бүгд F-статистикаар хүлээн зөвшөөрөгдөж байна. Үнэлэгдсэн тэгшитгэлүүдэд нийтлэг байдлаар хетрогийн болон автокорреляцийн нөлөө Breusch-Pagan, DW тестүүдээр илэрч байна. Эдгээр нөлөөг арилгасан тохиолдолд параметруудийн утга тодорхой хэмжээнд өөрчлөгдөх боловч эерэг, сөрөг нөлөөллийн гэмдэг өөрчлөгдөхгүй.

Тэгшитгэлийн тайлбарлах чадварууд нь харгалзан 0.79, 0.80, 0.26, 0.79 хувьтай байна. Эдгээрийн дотроос дотоод орлогын бие даасан байдлын тэгшитгэлийн үнэлгээ тайлбарлах чадвар муутай байна. Дөрвөн тэгшитгэлийн үнэлгээний параметрууд бүгд 10%, 5%, 1% итгэлцүүрийн магадлалын түвшинд статистикийн ач холбогдолтой гарчээ.

Орлогын бие даасан байдлын тэгшитгэлийн үнэлгээнээс харахад:

- Газарзүйн онцлогийн хувьд далайн төвшнөөс өндөр байх, ойн сангийн талбай их байх, хүн амын нягтрал өндөртэй байх нь орлогын бие даасан байдлыг нэмэгдүүлдэг. Харин усны эх үүсвэрийн тоо их байх нь орлогын бие даасан байдлыг бууруулж байна.
- Хүн амын онцлогоос зөвхөн шилжилт хөдөлгөөн орлогын бие даасан байдлыг нэмэгдүүлж байна. Харин хүн амын тоо, боловсролын индекс, эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо орлогын бие даасан байдалд нөлөөгүй гарчээ.
- Улс төрийн онцлогийн хувьд сонгуулийн жил орлогын бие даасан байдал нэмэгдэж, улмаар улс төрийн эрх мэдэлд хүрэхийн хирээр орлогын бие даасан байдал буурч байна.
- Эдийн засгийн онцлогийн хувьд өрсөлдөх чадвар нэмэгдэх нь орлогын бие даасан байдлыг нэмэгдүүлдэг, харин инфляц өсөх нь орлогын бие даасан байдлыг бууруулж байна.

Татварын орлогын бие даасан байдлын тэгшитгэлийн үнэлгээний параметрууд орлогын бие даасан байдлын тэгшитгэлийн үнэлгээний параметруудтэй ойролцоо гарсан байна. Ганц ялгаатай зүйл нь далайн төвшнөөс дээш өндөр байх нь татварын орлогын бие даасан байдалд нөлөөгүй байна.

Дотоод орлогын бие даасан байдлын хувьд далайн төвшнөөс дээш өндөр, шилжилт хөдөлгөөн, өрсөлдөх чадварын индекс эерэг нөлөөтэй, харин усны эх үүсвэрийн тоо сөрөг нөлөөтэй байна.

#### Хүснэгт 6. Панел регрессийн тэгшитгэлийн үнэлгээ

Үзүүлэлтүүд	Орлогын бие даасан байдал		Татварын орлогын бие даасан байдал	
	Коэффициент	T-статистик	Коэффициент	T-статистик
C	0.11397	1.713***	0.17477	3.870*
Газарзүйн онцлог				

Далайн төвшнөөс дээш өндөр	0.00005	1.930***		
Усны эх үүсвэрийн тоо	-0.00007	-4.990*	-0.00005	-4.239*
Ойн сангийн талбай	0.00006	2.277**	0.00004	1.764***
Хүн амын нягтрал	0.00082	2.299**	0.00150	4.994*
Хүн амын онцлог				
Хүн ам				
Шилжилт хөдөлгөөн	0.00006	4.125*	0.00005	3.905*
Боловсролын индекс				
Эдийн засгийн идэвхгүй хүн ам				
Улс төр, эдийн засгийн онцлог				
Улс төрийн эрх мэдэл	-0.03647	-1.935***	-0.03124	0.0589***
Сонгууль	0.10138	2.381**	0.11335	3.027*
Өрсөлдөх чадварын индекс	0.00427	6.893*	0.00289	5.853*
Ажилгүйдлийн түвшин				
Инфляц	-0.00593	-1.976**	-0.00534	-2.038**
R-squared	0.7945		0.7989	
Adjusted R-squared	0.7751		0.7811	
F-Statistic	41.0279		44.8609	
Prob(F)	0.0000		0.0000	
DW	0.5089		0.6067	
Breusch-Pagan test	0.0000		0.0000	
Hausman Test	0.0079		0.0017	
Effects	Fixed		Fixed	

Энд \*\*\* $p < 0.1$ , \*\* $p < 0.05$ , \* $p < 0.01$  утгыг илэрхийлнэ. Тухайн коэффициентод харгалзах стандарт хазайлтын утгыг харгалзуулан хаалтанд харуулав. Тооцогдоогүй үзүүлэлтийг “-” гэж тэмдэглэв. Breusch-Pagan test нь heteroscedasticity-г шалгадаг ба түүний магадлалын утга  $> 0.1$  бол хетроггүй гэж үзнэ. F-Statistic нь загварын ажиллагааг шалгадаг. Түүний магадлал  $< 0.1$  бол тухайн загварыг статистикийн хувьд хүлээн зөвшөөрдөг. R-squared нь тухайн үзүүлэлтүүдийн тайлбарлах чадварыг илэрхийлнэ.

Зарлагын бие даасан байдлын тэгшитгэлийн үнэлгээнээс харахад:

- Газарзүйн онцлогийн хувьд усны эх үүсвэрийн тоо зарлагын бие даасан байдлыг нэмэгдүүлдэг бол хүн амын нягтрал бууруулж байна.
- Хүн амын онцлог зарлагын бие даасан байдалд нөлөөгүй.
- Улс төрийн онцлогийн хувьд улс төрийн эрх мэдэл зарлагын бие даасан байдлыг нэмэгдүүлдэг, харин сонгууль бууруулж байна.

- Эдийн засгийн онцлогийн хувьд зарлагын бие даасан байдлыг өрсөлдөх чадвар бууруулж, инфляц өсгөж байна.

Үзүүлэлтүүд	Дотоод орлогын бие даасан байдал		Зарлагын бие даасан байдал	
	Коэффициент	T-статистик	Коэффициент	T-статистик
C	-0.7936	-2.397**	0.8263	15.835*
Газрын онцлог				
Далайн төвшнөөс дээш өндөр	0.00044	3.520*		
Усны эх үүсвэрийн тоо	-0.00019	-2.789*	0.00005	3.997*
Ойн сангийн талбай				
Хүн амын нягтрал			-0.00091	-2.619*
Хүн амын онцлог				
Хүн ам				
Шилжилт хөдөлгөөн	0.00015	1.877***		
Боловсролын индекс				
Эдийн засгийн идэвхгүй хүн ам				
Улс төр, эдийн засгийн онцлог				
Улс төрийн эрх мэдэл			0.04037	2.124**
Сонгууль			-0.09674	-2.238**
Өрсөлдөх чадварын индекс	0.01582	5.075*	-0.00404	-7.075*
Ажилгүйдлийн түвшин				
Инфляц			0.00651	2.154**
R-squared	0.2599		0.7862	
Adjusted R-squared	0.2109		0.7685	
F-Statistic	5.2972		44.366	
Prob(F)	0.0000		0.0000	
DW	0.7136		0.5607	
Breusch-Pagan test	0.0000		0.0000	
Hausman Test	0.0000		0.0031	
Fixed/Random	Fixed		Fixed	

Энд \*\*\* $\rho < 0.1$ , \*\* $\rho < 0.05$ , \* $\rho < 0.01$  утгыг илэрхийлнэ. Тухайн коэффициентод харгалзах стандарт хазайлтын утгыг харгалзуулан хаалтанд харуулав. Тооцогдоогүй үзүүлэлтийг “-” гэж тэмдэглэв. Breusch-Pagan test нь

heteroscedasticity-г шалгадаг ба түүний магадлалын утга  $> 0.1$  бол хетрогүй гэж үзнэ. F-Statistic нь загварын ажиллагааг шалгадаг. Түүний магадлал  $< 0.1$  бол тухайн загварыг статистикийн хувьд хүлээн зөвшөөрдөг. R-squared нь тухайн үзүүлэлтүүдийн тайлбарлах чадварыг илэрхийлнэ.

### Дүгнэлт

Энэхүү судалгааны ажлаар орон нутгийн санхүүгийн бие даасан байдлыг дөрвөн хэсэгт хуваан, түүнд нөлөөлөх газарзүйн, хүн ам, улс төр, эдийн засгийн хүчин зүйлүүдийг авч үзлээ. Эдгээр үзүүлэлтүүдийн сонголтыг энэ чиглэлээр хийгдсэн судалгааны ажлууд дээр үндэслэн гаргасан. Арга зүйн хувьд бид Панел регрессийн үнэлгээг ашигласан ба холбогдох тестүүдээр шалгасан.

Орон нутгийн санхүүгийн бие даасан байдалд нөлөөлөгч хүчин зүйлийг тодорхойлохдоо бид тайлбарлагч 13 үзүүлэлтийг хамруулав. Тус үзүүлэлтүүдийн дөрөв нь газарзүйн онцлогийг, дөрөв нь хүн амын онцлогийг, тав нь улс төр, эдийн засгийн онцлогийг илэрхийлж байв. Панел регрессийн тэгшитгэлийн үнэлгээнээс харахад орлогын, татварын болон зарлагын бие даасан байдлын тэгшитгэлүүд тайлбарлах чадварын хувьд ойролцоо үнэлэгджээ. Харин дотоод орлогын бие даасан байдлын тэгшитгэлийн тайлбарлах чадвар тааруухан гарсан. Зарлагын бие даасан байдлын тэгшитгэл нь орлогын бие даасан байдлын тэгшитгэлийн урвуугаар тайлбарлагдаж байгаа тул орлогын бие даасан байдлын тэгшитгэлд үндэслэн энэхүү судалгааны ажлынхаа дүгнэлтийг хийхийг зөв гэж үзэв.

Орлогын бие даасан байдалд параметруудийн хувьд хамгийн их мэдрэмжтэй нь улс төр, эдийн засгийн хүчин зүйлүүд байв. Дараа нь газарзүйн хүчин зүйлүүд орж байна. Орлогын бие даасан байдлын тэгшитгэлийн үр дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж болно. Үүнд:

- Далайн төвшнөөс дээш, ойн сангийн нөөц ихтэй аймгууд өөрсдийн санхүүгийн бие даасан байдлаа дээшлүүлж чадна.
- Гадаргын усны нөөц багатай аймгууд тухайн нутгийнхаа орчин нөхцөл, онцлогт дасан зохицсон байдаг тул газар доорх нөөцөө ашиглан санхүүгийнхээ бие даасан байдлыг хангаж чадна.
- Тухайн аймагт шилжин ирэгсэд хүн амын нягтралыг нэмэгдүүлж, зах зээлийн эрэлтийг тэлснээр санхүүгийн биеэ даах чадавхыг сайжруулж байна.
- Аль ч аймаг улс төрийн эрх мэдлийг хэнд шилжүүлэх вэ гэдгээ бодолцож байх шаардлагатай байна. Өмнөх бүх тохиолдлууд санхүүгийн бие даасан байдалд тодорхой хэмжээнд саад тотгор болж байжээ.

- Аймгуудын хөгжлийн гол зорилтуудын нэг нь өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд анхаарах хэрэгтэй. Өрсөлдөх чадварт орон нутгийн бодлогыг чиглүүлснээр санхүүгийн бие даасан байдлыг хангах бололцоотой.
- Тухайн аймаг өөрсдийн хүнсний нөөцийг хангах замаар нийлүүлэлтийн гаргалтаар инфляцийг хянаж чадвал орлогын бие даасан байдлыг тогтвортой хадгалах бололцоотой байна.

### **Ашигласан материал:**

- Beer-Tyth, K. 2009. Local financial autonomy in theory and practice The impact of fiscal decentralisation in Hungary. Switzerland: Faculty of economics and social sciences at the University of Fribourg .
- Bruckner, M., & Tuladhar, A. 2009, 11. The Effectiveness of Government Expenditures During Crisis: Evidence from Regional Government Spending in Japan 1990-2000. Retrieved from [http://crei.cat/files/filesActivity/36/Japan%2090s\\_Bruckner\(1\).pdf](http://crei.cat/files/filesActivity/36/Japan%2090s_Bruckner(1).pdf).
- CICA. 1997. Indicators of Government Financial Condition, Canadian Institute of Chartered Accountants. Toronto.
- Gomez, Z., Hernandez, L., & Bastida, H. 2009. Developing a model to measure financial condition in local government. *The American Review of Public Administration*, 39, 425-449.
- Kloha, P., Weissert, C. S., & Kleine, R. 2005. Developing and testing a composite model to predict local fiscal distress. *Public Administration Review*, 65, 313-323.
- Padovani, E., & Scorsone, E. 2011. Measuring Financial Health of Local Governments: A Comparative Framework. *Yearbook of Swiss Administrative*.
- Pratiwi, E. N. 2017. Financial independence of regencies and cities in Central Java. *Economic Journal of Emerging Markets*, 9, 199-209.
- Psycharis, Y., Zoi, M., & Iliopoulou, S. 2015. Decentralization and local government fiscal autonomy: Evidence from the Greek municipalities. *Environment and Planning C: Government and Policy*, 00, 1-19.
- Ritonga, I. T. 2014. *Modelling Local Government Financial Conditions in Indonesia*. Melbourne.
- Rivenbark, W., Roenigk, D., & Allison, G. 2009; 2010. Communicating financial condition to elected officials in local government; Conceptualizing

financial condition in local government. Popular Government; Journal of Public Budgeting, Accounting & Financial Management, 77; 22, 4-13; 149-177.

Бадамсайхан. 2012, 06 08. Монгол орны газарзүйн байрлал, онцлог. Retrieved from <https://tbadamsaikhan.blogmn.net>.

Сувд, Б. 2002. Монгол улсын эдийн засгийн аюулгүй байдал, шалгуур үзүүлэлтүүд. Улаанбаатар.